

Үндсэн хуулийн философи ба улс орнуудын түүхийн харилцан хамаарлын асуудалд

On the problem of interrelationship between constitutional philosophy and the history of countries

Чулууны Өлзийсайхан¹

*Доктор (Ph.D), профессор
Монголын Үндэсний Их Сургууль
chuluun.ulziisaikhan@yahoo.com*

Шагдарын Ганхуяг*

*Доктор (Ph.D), дэд профессор
Шинжлэх Ухааны Академийн
Философийн хүрээлэн
Философийн салбар
gankhuyagshagdar@gmail.com*

Ulziisaikhan Chuluun¹

*Doctor (Ph.D), professor
Mongolian National University
chuluun.ulziisaikhan@yahoo.com*

Gankhuyag Shagdar*

*Doctor (Ph.D), associate professor
Department of Philosophy,
Institute of Philosophy,
Mongolian Academy of Sciences
gankhuyagshagdar@gmail.com*

Хураангуй:

Энэхүү судалгааны өгүүлэлдээ улс орнуудын түүхэнд онцгой гэж хэлж болох үйл явдлууд үндсэн хуулинд ямар байдлаар тусгагддаг вэ, 1992 оны үндсэн хууль Монгол Улсын түүх, ард түмний онцлог байдлыг философийн үүднээс хэрхэн харж тусгасан бэ, олон дахин өөрчлөлт ордог, одоо ч дахин өөрчлөх гээд байдгийн цаад учир шалтгаан юу байна вэ гэдгийг шинэлэг байдлаар харуулахыг зорьсон болно.

Түлхүүр үгс: *Үндсэн хууль, улс төрийн философи, түүх ба үндсэн хуулийн харилцан хамаарал, Үндсэн хуулийн шинэчлэл, хууль тогтоох эрх мэдэл г.м.*

Abstract:

The Constitutional Law of any country is the basis of their political system, and the most important document regulating the social relations. Our main discussion would be - will these new amendments reflect the mistakes and lessons of previous Constitution law? How does the newly amended Constitutional law compare with other countries' constitutional laws? Does it promise growth and prosperity for Mongolia?

Keywords: *constitution, political philosophy, interrelationship between history and constitution, constitutional reform, legislative power etc.*

I. Оршил

Үндсэн хууль, түүхийн философийн асуудал судлаачдын анхааралд байнга байдаг сэдэв юм. Ялангуяа Монгол Улсын нийгэм судлаачид түүхийн философи, улс төрийн философийн чиглэлээр томоохон бүтээлүүд туурвих болсон байна. Эрдэмтэн судлаач Д.Болд-Эрдэнэ “Улс төрийн философи” (Уб.,

¹ © Зохиогч. 2022. Сэтгүүлд нийтлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээл нь зохиогчийн оюуны өмч байх бөгөөд (CC BY- <https://creativecommons.org/licenses/by/4.0/>) нөхцөлийн хүрээнд ашиглана уу.

* Холбоо барих зохиогч.

2015), Д.Лүндээжанцан, Н.Жалбажав Х.Сэлэнгэ, Д.Отгонтуяа нар “Эрх зүйн философи” (Уб., 2014), Р.Батмэнд “Монголын хөгжлийн бодлогын философи: Улс төрийн эдийн засгийн ухаанд холбогдох нь” (Уб., 2016) зэрэг нэгэн сэдэвт томоохон бүтээлүүдийг туурвижээ.

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлттэй холбоотой судалгаа, мэдээлэл, лавлагаа” (Уб., 2017) эмхэтгэлд дурдсанаар үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой 100 гаруй судалгааны ажил гүйцэтгэсэн байна. Энэ мэтээр үндсэн хуулийн талаар, улс төрийн хөгжил, улс төр, эрх зүйн философийн чиглэлээр нилээд ажлуудыг манай эрдэмтэн судлаачид хийж бүтээжээ. Дэлхийн философи сэтгэлгээний түүх ч эрхийн философи, түүхийн философийн талаар бүтээл туурвилуудаар баялаг. Гегелийн “Эрхийн философи”, “Түүхийн философи” бүтээлүүд бол философи сэтгэлгээний түүхэнд томоохон байр суурь эзлэдэг төгс бүтээлүүд юм.

Тухайлбал, “Үндсэн хуулийн философи ба улс орнуудын түүхийн харилцан хамаарлын асуудалд” гэсэн энэхүү судалгааны өгүүлэлдээ улс орнуудын түүхэнд онцгой гэж хэлж болох үйл явдлууд Үндсэн хуулинд ямар байдлаар тусгагддаг болох, улмаар 1992 оны ардчилсан “шинэ” Үндсэн хууль Монгол Улсын түүх, ард түмний онцлог байдлыг философийн үүднээс хэрхэн харж тусгасан эсэх, олон дахин өөрчлөлт ордог, одоо ч дахин өөрчлөх гээд байдгийн цаад учир шалтгаан юу байна вэ гэдгийг шинэлэг байдлаар харуулахыг зорьсон болно.

II. Судалгааны арга зүй

Энэхүү судалгааны өгүүллийг бичихдээ түүхчлэх, харьцуулах аргууд, бодлогын болон баримт бичигт анализ хийх арга зүйг ашиглав.

Өгүүлэлд улс орнуудын түүхэнд гарч байсан томоохон үйл явдлууд ямар байдлаар үндсэн хуулиудад тусгагдсан учир шалтгааныг гаргахыг хичээсэн бөгөөд үүнд тулгуурлан Монгол Улсын Үндсэн хуулийг өөрчлөх, шинэчлэх талаар төр засгийн зүгээс бодитой алхам хийж байгаа өнөө үед түүхийн үйл явцад философи сэтгэлгээгээр хандаж, түүхийн учир шалтгаан, Монгол Улсын болон монголын ард түмний тусгаар тогтнол, оршин тогтнох асуудлыг хэрхэн тусгах талаар асуудал дэвшүүлж судлаачид, шийдвэр гаргагчдын анхаарлыг үүнд чиглүүлэх зорилго тавьсан болно.

Дэлхийн улс орнуудын хөгжил цэцэглэлтийг харьцуулж үзвэл өөр хоорондоо асар их зөрүүтэй, хүн зоны амьдралын түвшин, сэтгэл ханамж, төр засагтаа итгэх итгэл улс орныхоо хөгжлийг дагаад өөр өөр байгаа нь олон судалгаагаар харагддаг. Учир нь нийгэм нь өөрөө бүхэл бүтэн систем, харилцан хамааралтай, амьд организм шиг эрүүл, тэнцвэртэй төлөвийг олж чадсан бол эрч хүч дүүрэн, хөгжиж дэвжих нөөц боломж сайтай байна. Харин энэ организм нэгэнт хөгжих боломжгүй, иргэд хичнээн эрч хүч, хөдөлмөрөө зориулаад ч аж амьдрал нь сайжралыг олж чадахгүй байгаа бол нийгмийн зохион байгуулалтыг ямар нэг байдлаар өөрчлөн сайжруулах гэсэн үйл ажиллагаа явагдаж ирсэн нь хүн төрөлхтөний бүхий л түүхээр нотлогддог. Энэ тохиолдолд системийг гацааж буй хэсгүүд хохирол амсч өөрчлөгдөхөөс өөр гарц үлдэхгүй. А.Ж.Тойнби “Түүх судлал” хэмээх бүтээлдээ «...Ямар нэг шинэ хүчний зүгээс нийгмийн организмыг өдсөн сэдэлгийг хохиролгүйгээр

үгүйсгэх аргагүй... ийм нөхцөл байдалд гагцхүү хуучин бүтцийг шинэ элементэд зохицуулбал нийгмийн эрүүл мэндийг хамгаалж болох юм. Өөрөөр хэлбэл шинэ нөхцөлд эсэн мэнд байя гэвэл нийгмийн бүтцийг сайтар шинэчлэх хэрэгтэй»[1] гэж өгүүлсэн байх ажээ.

Шинэ соёл, шинэ итгэл үнэмшил, шинэ улс төрийн систем бий болоход хуучин бүтэцтэй ямагт зөрчилд орно. Шинэ зүйл нь системийн өөрийн дотоод мөн чанараас болсон уу, эсвэл гадаад хүчин зүйлсийн нөлөөлөөс болсон уу гэдгээс үл хамаарч энэ зөрчил ямар нэг байдлаар шийдвэрлэгдэнэ. Шинэ бүтэц гарч ирсэн л бол хөгжлийн диалектикаараа хуучин бүтэц шинэчлэн өөрчлөгдөж таардаг. Хуучин хэлбэр нь шинэчлэлт өөрчлөлтийг хүлээж авахгүй хуучин байдлаараа байвал нийгмийн өөр нөхцөл байдалд үр ашигтай ажилладаг шинээр бий болох гэж буй элемент магадгүй эвдлэн сүйтгэх, хувьсгал хийх замаар үйлдлээ хийж эхлэх болно. Улс орнуудын улс төрийн системийн өөрчлөлт, үндсэн хуулийн өөрчлөлтүүд яг ийм маягаар хуучныг өөрчилж, гэхдээ энэ өөрчлөлт нь зарим тохиолдолд тайван замаар, зарим тохиолдолд хувьсгалт өөрчлөлтийн замаар хийгдэж иржээ. Гэхдээ тайван болон хувьсгалт өөрчлөлтийн аль ч замаар хийгдсэн байсан ч улс орны амин чухал асуудал, түүхийн онцгой үйл явдлууд уг үндсэн хуулинд тод томруун ул мөрөө үлдээж, чухал байр сууртай хуулийн хэм хэмжээ болон үлддэг байна. Чухам энэ асуудлыг хөндөж, зарим нэг улс орны түүхийн жишээгээр нотлох гэж энэхүү өгүүллийг бичлээ.

Ш. Судалгааны үр дүн

Ардчилал, эрх чөлөөний эх орон АНУ-ын түүх, АНУ-ыг үндэслэн бий болгосон ард түмний туулж ирсэн амьдрал, тэмцэл нь ийм л улс, ийм л эрх чөлөөг бий болгохоос өөр гарцаагүй байсан юм. Тэд энэ улсыг өөрөөр үндэслэн бий болгох боломжгүй байсан. Гегель Түүхийн философи хэмээх алдарт бүтээлдээ «...Түүхийг эрэгцүүлэн бодоход философи руу авчирдаг цорын ганц зүйл бол шалтгааны тухай энгийн ойлголт юм. ... Тиймээс дэлхийн түүх бидэнд оновчтой үйл явцыг харуулж байдаг. Итгэл үнэмшил, зөн совин нь түүхийн хүрээний таамаглал юм. Философийн хувьд энэ нь ямар ч таамаглал биш. Таамаглал нь шалтгаанаар нотлогддог. ...Учир шалтгаан бол орчлон ертөнцийн мөн чанар, өөрөөр хэлбэл, бүх бодит байдал оршин тогтнох боломжийг олгодог зүйл юм»[2] гэж бичсэн байдаг. Гегелийн түүхийн философийг шалтгаантай холбож авч үзэж байсан энэ үзэл дээр тулгуурлан авч үзэхэд АНУ эрх чөлөө, ардчилал, тэгш эрхийн эх орон болохоос өөр тавилан байгаагүй, тэр нь ч АНУ-ын Үндсэн хуулинд яг л тэр байдлаараа тусгагдсан.

Түүхийг сөхөх ахул, европ даяар протестант шашны ялгаварлан гадуурхалт хэдэн зууныг дамжин үргэлжилсэн байдаг. 1553-1558 онд Англи улсыг захирч байсан Мари хатан хааны үед нэн онцгой хатуу ширүүн байсан учраас Хатан хаан Цуст Мари (Bloody Mary) гэж нэрлэгдэн түүхэнд үлдсэн байдаг. Маригийн дараа Анхдугаар Элизабет хатан 1558 онд хаан ширээнд суухдаа шашны протестант шинэ урсгалыг битүүдээ дэмжихийн сацуу Ромын католик шашинтай эвлэрэнгүй хандаж байв. Католик шашныг олон урсгалтай протестант шашинтай нийлүүлэх гэсэн түүний санаа Ромын хамба ламын дургүйг хүргэж, 1570 онд Элизабетийг хууль бус гэж шашны хэргээс

зайлуулах лүндэн буулгаж байжээ. Элизабет хатан хаан Английн сүмийг бие даасан болгож католик сүм хийдээс салангид болгосон нь шашны зөрчлийг улам хурцатгасан байдаг. 1603 онд Элизабет хатан хаан нас барж Стюард хаан гарч ирснээр шашны зөрчил улам бүр хурцдаж шинэ урсгалыг ихэд хавчих болсон нь англичууд гадагшаа цагаачлахад их түлхэц өгчээ. Ялангуяа пуританчуудыг буруу номтон гэж цээрлүүлж байсан нь харгислалыг сөрж католик сүмийн ёс жаягийг дагалгүй чөлөөтэй аж төрөх хүсэлтэй, шинэ нутагт аз турших бодолтой хүмүүсийн тоог улам нэмэгдүүлжээ. Тиймээс тэд олноороо америк тивийг зорих болжээ. Америк тивд ... ч шашны ялгаварлан гадуурхалт асар их байж хэлийг нь хайрах, чихийг нь огтлох, зодож занчих арга хэмжээнүүдийг ч авч байлаа. 1660 онд номлогчдыг Бостон хотод дүүжилж алах явдал ч гарч байв[3].

Эндээс харахад АНУ-д цагаачилж очсон иргэд бол протестант шашин шүтдэгийнхээ улмаас европд хавчигдан зовсон хүмүүс, тэдний ар гэр байлаа. Тэдний гардуурхагдаж, хавчигдаж зовох нь америк тивд ч, европ тивд ч адилхан байсан. Шашны энэ ялгаварлан гадуурхалт, өшөө хорсол нь нь европын улс орнуудыг 30 жилийн турш дайн дажны хөлд нэрвэгдүүлэн зовоход хүргэсэн юм. “Тучин жилийн дайн 1618-1648, шашин газар нутаг, хаан ширээ, худалдааны төлөө дайн. Хабсбургийн угсааны Ариун Ромын эзэнт улс болон Швед, Нидерланд зэрэг католик шашныг эсэргүүцэгч улсуудын дэмжлэгийг авсан протестант ванлигуудын хооронд болсон. Тулалдаанууд ихэвчлэн Германы газар нутаг дээр их өрнөсөн. Энэ цуст дайн 1648 онд Вестфалийн энхийн гэрээгээр төгсчээ”[4].

Ийм нөхцөл байдал зуун дамжин үргэлжилж, тив алгасан ирсэн байсан учраас АНУ-ыг үндэслэн байгуулж, энэ тив, энэ улсад шинэ нийгмийг цогцлоон байгуулахад дахин энэ дайныг үргэлжлүүлэх боломжгүй байсан юм. Америк тивд протестант шашны олон урсгалуудыг шүтэгчдийн зэрэгцээ католик шашинтнууд ч олноороо зэрэгцэн амьдарч байсан юм. Иймээс тайван амьдрах, дайнгүй амьдрахын тулд бие биенээ хүлээн зөвшөөрөх, хэн хэндээ хүндэтгэлтэй хандах, байгалиас заяасан эрхийг нь хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй байжээ. Түүх тэдэнд эрх чөлөө, ардчиллын эх орон болгох гарцаагүй зүйлийг тулгасан. Тиймээс АНУ-ын үндсэн хуулинд янз бүрийн шашинтай, янз бүрийн үндэс угсаатай иргэдээ төр улсаа цогцлоон байгуулахад тэгш эрхтэй оролцох, хэн нь ч хэнээсээ давуу эрх эдлэхгүй байх тийм төрийн байгуулалтыг бодож олохтүүхэн даалгаврыг өгсөн байна. АНУ-ыг үндэслэгчид энэ даалгавраа сайн биелүүлсний тод жишээ бол өнөөг хүртэл зохион байгуулалтаа өөрчлөөгүй АНУ-ын конгресс юм. АНУ-ын Үндсэн хуулийн 1-р зүйл. 2-р хэсгийн 3-т Нэгдсэн улсын хууль тогтоох бүрэн эрхийг эдлэх Конгрессийн Төлөөлөгчдийн танхимыг байгуулах талаар заахдаа “Төлөөлөгчдийн тоо болон шууд албан татварыг энэхүү нэгдсэн улсын бүрэлдэхүүнд оролцогч Муж улсуудын хооронд тэдгээрийн **хүн амын тоонд хувь тэнцүүлэн хуваарилна**”. “1-р зүйл, 2-р хэсгийн 5-д “төлөөлөгчдийн танхим нь дарга, бусад албан тушаалтныг сонгох бөгөөд гагцхүү энэ танхим Импиachmentийн төрийн дээд албан тушаалтныг албан тушаалаас нь огцруулах, эрүүгийн хариуцлагад татах асуудлыг хэлэлцэх эрх эдэлнэ”[5] гэж заажээ.

Харгис хэрцгий нэг бие хүн, нэг хааны угсаа гарал, шашин шүтлэгээс үй олон хүн, олон сая протестант шашинтны туулсан зовлон нь хамаарч байсан түүхийн сургамжаас үүдэн нэг хүнд эрх мэдэл төвлөрүүлэх асуудал дээр АНУ-ыг үндэслэгчид ихээхэн мэтгэлцээн өрнүүлж, анхаарал тавьж байж асуудлыг шийдсэн байдаг. АНУ байгуулагдах үед Ерөнхийлөгчийн засаглалын талаар либералууд болон демократ үзэлтнүүдийн хооронд ширүүн мэтгэлцээн өрнөж байв. Энэ нь хүчтэй гүйцэтгэх засаглал болон ард түмний засаглал хоёр үл нийцнэ гэсэн хэлбэрээр илэрхийлэгдэж хурцадмал байдалд хүргэж байв. Үндсэн хуулийг шүүмжлэгчид нь ард түмний хувцас өмссөн хаан байна гэсэн байдлаар эрс эсэргүүцэж байв. Ерөнхийлөгчийн засаглалыг дэмжигчид түүний дотор Александр Хамилтон гүйцэтгэх засаглал нь ард түмний санаа бодлыг улам боловсронгуй болгож өргөжүүлэхээс гадна ард түмнийг өөрийгөө хамгаалах, олонхийн хүсэл зоригоос хувь хүний эрх чөлөөг хамгаалах гэсэн бүгд найрамдах засаглалын нэг амин чухал хэсэг байх болно гэж үзэж байжээ. Абрахам Линкольн “эрх чөлөөний эрдэнэ” гэж нэрлэсэн зүйлийг хамгаалах онцгой үүрэг хүлээсэн бөгөөд ард түмнээс шууд бус, сонгогчдын коллегииор сонгогдсон гүйцэтгэх засаглал нь **ард түмний олонхийг хязгаарлаж улс орны үйл хэргийг тогтвортой удирдан чиглүүлнэ** гэж үзэж байсан юм[6] Энд шууд ард иргэдээс биш сонгогчдын коллегииор дамжуулах шаардлага нь хүн амын дотор илүү олон тоотой болсон аль наг шашныг баримтлагчид үргэлж гүйцэтгэх засаглал дээр ноёрхлоо тогтоохоос сэрэмжилсэн явдал бөгөөд хууль тогтоох конгресс нь сенатад муж бүрээс 2 хүн, төлөөлөгчдийн танхимд иргэдийн тооноос хамаарсан гишүүдийг сонгосон нь цөөнхийг олонхийн ноёрхлоос хамгаалсан маш ухаалаг тооцоолол, ухаалаг шийдвэр болсон байдаг.

АНУ байгуулагдах үед Английн төр засгаас колониуддаа явуулж байсан эдийн засгийн хатуу бодлого нь АНУ-ын Үндсэн хуулинд мөн тод томруун ул мөрөө үлдээж түүнээс хамгаалах хууль эрх зүйн нөхцлийг бий болгоход хүргэсэн байдаг. Англи улс колониуддаа түүхий эдийн бааз болгох, нөгөө талаар бараа таваараа борлуулах зах зээл болгон ашиглах бодлого явуулж бусад улсуудын бараанд өндөр татвар оногдуулах, усан тээвэрт ганцаараа ноёлох меркантилист бодлого баримталж байв. “1660 онд худалдаа, зам харилцааг чиглүүлэх анхны хууль батлагдан гарав. Америкийн эдийн засаг өөрчлөгдөхийн хэрээр бусад олон зөрчилтэй асуудлууд бий болжээ. Тиймээс 1663 онд Тамганы хууль батлан гаргаж Европын бусад хэсгээс Америкийн колони руу бараа бүтээгдхүүнийг тээвэрлэхээсээ өмнө заавал Английн боомтоор дамжин өнгөрсөн тохиолдолд зөвшөөрөл олгодог болжээ”[7]. Англи улсаас явуулж байсан энэ бодлого нь урт удаан хугацааны туршид америкт шилжин суурьшсан иргэдийн аж амьдралаа дээшлүүлэх, хөгжин дэвжих бүхий л боломжийг хааж туйлдуулж байсан. Үүнийг эсэргүүцсэн олон тэмцэл хөдөлгөөнүүд ч өрнөж байсан. Бостоны далайн боомтод оруулж ирсэн усан онгоцонд ачсан цайг далайд живүүлж байсан тэмцлийн түүх ч байх ажээ. Ийм, өөрсдөд нь дэмжлэг болохгүй, бас хөгжих боломж олгохгүй дарамтыг дахин амсахгүй гэж АНУ-ын Үндсэн хуулинд нэг заалт орж ирсэн нь 1-р зүйлийн 9-р хэсгийн 6-д “Аливаа худалдааны болон санхүүгийн талаар нэг Муж улсын боомт нөгөөгийнхөөс илүүд тооцогдох давуу байдал тогтоож болохгүй. Аль

нэг Муж улсаас нөгөө рүү ирж, буцаж яваа хөлөг онгоцыг өөр муж улсын усан боомтод албадан оруулах, ачааг нь буулгуулах, эсвэл гувчуур төлүүлэхийг хориглоно”[8] гэсэн заалт байсан юм.

Дэлхийн түүхэнд томоохон байр суурь эзэлж сайн болон саар талын аль алиныг нь хүн төрөлхтөнд харуулсан ард түмэн бол германчууд билээ. Германчууд 1914-1918 оны хооронд үргэлжилсэн Дэлхийн I дайныг эхлүүлсэн гол буруутан бөгөөд энэ дайнд 70 саяас багагүй цэргүүд байлдаж 9 саяас багагүй хүн амь үрэгдэж, 21 сая хүн шархдаж, 7.7 сая цэргүүд сураггүй алга болсон статистик байдаг байна. Энэ дайны буруутанд хүлээлгэсэн хариуцлага шийтгэл нь германы эдийн засгийг бүрмөсөн сүйрүүлж дараагийн дайнд хүргэсэн бөгөөд ийм дайныг өдөөгч, турхирагч улс төрийн хүчнийг германы засгийн эрхэнд гаргахад хүргэсэн юм. Гитлер дайнд нийгмийг уриалахдаа үндэс угсаагаар ялгаварлан гадуурхах үзэл дээр тулгуурлаж эхний алхмуудаа хийсэн. Фашист дэглэмийг хэрэгжүүлсэн 2 орны нэг болж анхнаасаа арьсны үзэл, еврей нарыг үзэн ядахад чиглэж хорих лагерь, гестапо буюу улс төрийн цагдаагийн газар, алан хядлага өргөн хэмжээнд дэлгэрч эхэлсэн байдаг. Энэ алхамууд нь Германд өмнөх дэглэмийн үндсэн хуулийн өнгө төрхийг аажим аажмаар үгүй хийсэн юм. Ажилчдад, нийгэмд хандсан уриа, илтгэл, үг хэллэг нь хүмүүсийг татах ихээхэн увидастай байжээ. “Рейхстагийг албан ёсоор татан буулгаж 1933-1-30нд Гитлер канцлераар томилогдсон . 5-р сарын 5-нд болсон сонгуулиар 44%-ийн санал авсан Гитлерийн Германы Үндэсний социалист нам нь 81 коммунист депутатыг хөөлгөснөөр үнэмлэхүй олонхи болсон. Дараа нь социалдемократ болон бусад намуудыг татан буулгаснаар 1933-7-14-нд Үндэсний Социалист Нам Төрийн ганц нам болохоо зарласан байдаг. Үүнээс хойш Нацистууд, гестапогийн аймшигт аллага, хядлага аажмаар ноёрхох болсон. Еврейчүүдийн эсрэг тэмцэл нь урьд өмнө үзэгдэж харагдаагүй хүчирхийллийн хэмжээнд хүрчээ. Хэрцгий бүдүүлэг үеийн түүхэн дэх ямар ч аллага хядлага 6 сая еврей хүнийг хүйс тэмтэрсэн хэмжээнд хүрээгүй”[9] гэж францын улс төр, үндсэн хууль судлаач М.Дюверже тэмдэглэсэн байдаг. Гитлер, нацистуудын өдүүлсэн, герман улсын түүхэнд хар мөр үлдээсэн Дэлхийн II дайн нь хүн төрөлхтөний түүхэн дэх хамгийн аймшигтай дайн байсан юм. Энэ дайнд 61 улс орон татагдан орсон бөгөөд дэлхийн хүн амын 80% оролцож, 110 сая хүн цэргийн албанд татагдаж, нийтдээ 60 саяас илүү хүн нас баржээ. Энэ дайн 1939-9-1-нд Герман улс Польш руу довтолсоноор эхэлж дараа нь Герман улс Франц, Их Британи болон тэдгээрийн холбоотон улсууд руу довтлон дайныг өргөжүүлсэн. 1941-6 сард Герман ЗХУ руу довтолжээ. Улмаар энэ дайн Ази, Номхон далайд үргэлжилж 1945-5-8-нд Герман бууж өгснөөр дайн дууссан.

Түүхийн энэ сургамж өнөө цагийн ХБНГУ-ын Үндсэн хуулийн эхнээс нь , оршил хэсэгт нь хүртэл нэвт тусгагдсан байна. ХБНГУ-ын үндсэн хуулийн оршилд “Бурхан болон хүний өмнө хүлээх хариуцлагаа ухамсарлаж, Нэгдмэл Европын тэгш эрхэт нэгэн хэсгийн хувьд даян дэлхийн энх тайвны үйлсэд хүчин зүтгэх хүсэл эрмэлзлэлээр зоригжиж, Германы ард түмэн хууль тогтоох эрх мэдлээ хэрэгжүүлж энэхүү Үндсэн хуулийг батлан гаргав”[10] гэжээ. Энд бурханы болон хүн төрөлхтөний өмнө энх тайван байдлыг сахин хамгаалах явдлыг Германчууд өөрсдийн газар нутаг дээр амьдрах бүх хүн, байгууллагын

хамгийн эхний, хамгийн нандин журамт үүрэг болгон тунхаглажээ. Хүн төрөлхтөний өмнө тийм том дайн өдүүлсэн улс орны хувьд хамгийн их болгоомжлох зүйл, түүхийн хамгийн том сургамж тул энэхүү хуулийн заалт байр сууриа ийнхүү тэргүүн эгнээнд эзэлсэн байх ажээ.

Дэлхийн 2-р дайны үед хамгийн их зовлон үзсэн ард түмэн бол еврейчүүд байв. Бөөнөөр хорих лагериудад 6 сая орчим еврей хүмүүс тамлал, зовлонг туулан амь эрсдсэн нь хүн төрөлхтөний түүхэн дэх хамгийн аймшигтай яргалал байжээ. Энэ аймшигийг үйлдсэн харгис удирдагчдыг төрүүлсэн ард түмэн хүн төрөлхтөний өмнө бас гэмээ ухамсарласан, дахин ийм балмад зүйл хийхгүй байх амлалт болгож өөрийн үндсэн хуулиндаа дараахь чухал заалтуудыг оруулжээ. Үндсэн хуулийн доторхи бүтцэд хамгийн эхэнд энэ заалтууд орж тунхаглагдсан байх ажээ. Үүнд: 1-р хэсэг. 1-р зүйлийн 1-д Хүний нэр төр халдашгүй байна. Түүнийг хүндэтгэх ба хамгаалах нь төрийн бүх эрх мэдэлтний үүрэг мөн. 1-р хэсэг, 1-р зүйлийн 2-т Германы ард түмэн хүний эрхийг халдашгүй ба салшгүй хэмээн үзэж аливаа нийгэм, даян дэлхийн энх тайван, шударга ёсны үндэс суурь хэмээн хүлээн зөвшөөрч байна. 2-р зүйлийн 2-т Хүн бүр амьд явах эрхтэй бөгөөд хүний бие халдашгүй байна. Хувийн эрх чөлөө халдашгүй байна. 3-р зүйлийн 3-т Хэн ч хүйс, угсаа, арьсны өнгө, хэл, эх орон, төрсөн газар, итгэл үнэмшил, сүсэг бишрэл болон улс төрийн үзэл бодлын улмаас хохирох эсвэл давуу байж үл болно[11].

ХБНГУ-ын үндсэн хуулинд олон улсын энх тайван харилцааг зөрчиж болзошгүй, эсвэл энэ зорилгоор хийж буй үйлдэл, ялангуяа цэргийн түрэмгийлэлд бэлтгэх ажиллагаа нь үндсэн хуульд харшилна, тэдгээрийг гэмт хэрэг гэж үзнэ гэж заасан байна. Тэр ч байтугай үндсэн хуульд ёсыг устгахыг оролдсон хэн бүхний эсрэг шүүхийн журмаар хамгаалах боломжгүй бол бүх германчууд эсэргүүцэл үзүүлэх эрх нь хамгаалагдан үндсэн хуулинд тусгагджээ. Учир нь Гитлер засгийн эрхэнд гарахдаа тухайн үед үйлчилж байсан хуулийн дагуу гарч ирж аажимдаа дайнч үйл ажиллагаа руу шилжсэн билээ. Иймд үүнээс болгоомжилж энх тайван байдлыг хуулиар хамгаалах боломжгүй бол тэмцэх эрхийг нь бас хангаж өгсөн байна.

Польш Улсын газар нутаг бол геополитикийн хувьд олон дайнч улсуудаар хүрээлэгдсэн улс юм. Дэлхийн дайннуудын томоохон хэсэг нь польшийн газар нутаг дээр өрнөж байсан. Дэлхийн II дайны үед Польшийн Краков хотын захад байрлах Освенцим хорих лагерьт гэхэд гитлерчүүд 1.5 сая хүнийг амьдаар нь шатаасан бөгөөд тэдний 90 гаруй хувь нь еврейчүүд байжээ. Энэ дайнд Польш улс нийт хүн амынхаа 21.3% буюу 6.02 сая хүнээ алджээ. Дайнч улс гүрнүүдтэй хил залгаа оршдог, дайны хөлд үргэлж нэрвэгдсээр ирсэн нь энэ улсыг гадаад бодлого дээр тун хянамгай, болгоомжтой байхад хүргэсэн түүхийн сургамж үлдээжээ. Тийм ч учраас 26-р зүйлийн 2-т Зэвсэгт Хүчин нь улс төрийн асуудлаар **төвийг сахиж, иргэний болон ардчилсан хяналтанд** байхаар хуульчилжээ. Дайн энхийн асуудлыг хэн нэгэн улс төрч, улс төрийн хүчний сэтгэлийн хөөрлөөр биш харин нийт ард түмний ашиг сонирхлын үүднээс асуудлыг шийдэхээр хуулийн зохицуулалт хийжээ. Мөн ямар нэгэн дайн өдүүлэхээр санаархсан этгээдийг насан туршид нь гэмт хэргийн улмаас хариуцлага хүлээлгэхээр заасан нь ямар нэгэн улс төрч, улс төрийн хүчин түүхийн өмнө шүүгдэхээр болгож өгсөн нь хэн ч дайны аюулыг

Польш улсын зүгээс эхлүүлэхгүй байх шаардлаг болж хуульчлагджээ. 46 дугаар зүйл Дайны гэмт хэрэг, хүн төрөлхтөний эсрэг үйлдсэн гэмт хэргийг хугацаа хэтэрсэнд тооцохгүй гэсэн байна[12]. Бүгд Найрамдах Польш Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1-т зааснаар Бүгд Найрамдах Польш Улсын Зэвсэгт Хүчин нь улсын тусгаар тогтнол, түүний нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалахад үйлчлэх ба түүний хил хязгаарын халдашгүй, аюулгүй дархан байдлыг хангахад л үйлчлэх ёстой байна. Мөн Освенцимийн хорих лагерьт олон сая хүмүүсийг эмнэлгийн туршилтанд оруулж яргалан зовоож байсныг биеэр туулсан ард түмний хувьд Үндсэн хуулийнхаа 39-р зүйлд “Өөрийнх нь сайн дурын зөвшөөрөлгүйгээр хэнийг ч шинжлэх ухааны, түүний дотор эмнэлгийн туршилтанд оруулах ёсгүй” гэж заасан байх ажээ[13].

Одоо Монгол Улсын түүхийн философи Монгол Улсын үндсэн хуулинд хэрхэн тусгагдсан, үр дүн нь ямар байгааг эрэгцүүлэн харахыг хичээе. Монгол Улс бол өргөн уудам тал нутагт тархан суурьшдаг, нэг хавтгай дөрвөлжин километрт ноогдох хүн амын тоогоор хамгийн сийрэг, буюу ердөө 2 хүн оногддог. Монголчууд бид улс орноо түйвээж хэдэн сая хүнээ алдах хэмжээний дайн дажинг өөрийн нутаг дээрээ үзээгүй. Хэдийгээр дайн байлдаан хүн төрөлхтний аль ч ард түмний түүхтэй салшгүй холбоотой байдаг ч европ тив, африк, азийн зарим орнуудад гарч байсан олон сая хүний амийг бүрэлгэсэн улс хоорондын болон иргэний дайн шиг тийм хэмжээний дайныг үзээгүй азтай ард түмэн. Геополитикийн үүднээс бол газар нутаг, хүн амын онцлогоос ийм зүйл бараг боломжгүй. Газар хөдлөлт, цунами гэх мэт байгалийн хүчин зүйлүүд ч нэг их санааг нь зовоодоггүй. Харин монгол хүн бүрийн зүрх сэтгэлд үргэлж санаа зовж байдаг зүйл бол өргөн уудам, баян тансаг газар шороогоо бүрэн бүтэн байлгах, үндэс угсаагаа хамгаалах, тусгаар тогтнолоо хамгаалах гэдэг л асуудал байсан. Түүхийн бүхий л үед ийм л байсан, одоо ч энэ хэвээр л үргэлжилж байна. Гадаад орны эрдэмтэн судлаачид ч үүнийг анхаарч өөрсдийн бүтээд туурвилдаа үлдээсэн нь бий. Нэрт эрдэмтэн Л.Н.Гумилёв Евроазийн түүхээс хэмээх бүтээлдээ «1405 онд Мин улсын хятадууд тангад газрыг эзэлснээс хойш тангадууд алга болжээ. ...Эдүгээ монголын этногенез “алтан намар” цагийн инерцийнхээ үе шатанд орлоо. Тэдний соёл иргэншил 300-400 жилийн дараа дахин цэцэглэнэ гэдэгт найдна. Гэхдээ хүннү, түрэгүүдэд тохиолдсон шиг ямарваа нэг хорон санаа Монголын хөгжлийг гаднаас нь тасалдуулчихгүй бол шүү. Ингэхгүй гэдэгт найдъя. Угсаатан бол уян хатан бас хэлбэр төрхөө хадгалж чаддаг цогцос билээ. Түүний хэлбэр төрхийг алдагдуулах, доргиох, тэр тусмаа устгаж алга болгох боломж зөвхөн этногенезийн үе мөчлөг солигдох үед үүсдэг. Ингэхэд хүмүүс үхэж үгүй болохгүй, гагцхүү шинэ угсаатны бүрэлдхүүнд орчихдог» гэж бичжээ. Энд Монголын хөгжлийг гаднаас тасалдуулах аюул байж болох, монгол угсаатан өөр угсаатанд уусан алга болж болох аюул байдгийг бодитой харж бичжээ. Одоо ч иргэд тусгаар тогтнол, монгол угсаа гарвалыг хадгалж үлдэх, монгол хэл соёлоо аварч үлдэх талаар улам их анхаарч ярьж бичих болсон. Монгол Улсын Үндсэн хуулинд монголын ард түмний санаа зовж байдаг энэ асуудал төдийлөн баталгаатай биш, хамгаалалт муутай байдгаас

үүдэлтэй байж болно. Энэ аюул төрийн байгуулалтын хувьд ч, эдийн засгийн аюулгүй байдлын хувьд ч аль алинд нь байгаа гэж үзэж болно.

Энэ асуудлыг хуулийн тодорхой заалтууд дээр нухацтай эрэгцүүлж учир шалтгааныг тайлбарлахыг оролдоё. Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2-т Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн гэж заасан. Нийтийн гэдэг үгэнд дэлхийн бүх хүн газар, газрын хэвлийн баялгийг эзэмших боломжийг нээсэн гэж нийтээрээ эсэргүүцдэг. Бодит байдал дээр ч уул уурхайн маш олон лицензүүд гадныханд очиж тэр нь хүлээн зөвшөөрөхүйц нөхцлөөр олборлолт хийлгэдэг. Энэ нь ард түмний хамгийн их санаа зовоодог асуудал, хэзээ ч эвлэрэхгүй, түүхийн учир шалтгаанаар нөхцөлдсөн зүйл юм. Бид асуудлыг улс төрийн философийн үүднээс авч үзвэл төр нь зохицуулах, хязгаарлах буюу албадах, мөн улс орон ард түмний аюулгүй байдлыг хангах үүрэгтэй. Түүхээр нөхцөлдсөн ухамсрын хүчин чармайлт, төр улсынхаа оршин тогтнох үндсийн талаархи төсөөлөл, итгэл үнэмшил дээр ард түмний улс төрийн философи оршин тогтноно. Гэтэл Үндсэн хуулийн дээрх зохицуулалт хэдэн зуун, мянганыг дамжин ирсэн монголчуудын улс төрийн сэтгэлгээ улс төрийн философитой огтхон ч авцалдаж өгөхгүй байгаа билээ.

Улс төрийн философийн үндсэн гол асуудлууд нь

- “Хүн, түүний улс төр, оюуны хэрэгцээ эрх ашиг, сонирхол, үзэл үнэлэмжийн асуудал
- Нийгмийн улс төрийн оршихуйн ертөнц
- Хүний оюун санаа, ухамсар, оюунлаг танин мэдэхүйн арга хэлбэр”[14] байх ёстой.

Төр засгийн бодлого шийдвэр нь үүнд зохицож байвал ард түмэн хүлээн зөвшөөрнө, нийцэхгүй бол үргэлж өөрчлөхийг хүсэмжлэх нь гарцаагүй. Жан Жак Руссо төрийн эрх барих, жирийн ард иргэд хоёрын хоорондын харилцааг гэрээ гэж авч үзсэн байдаг. «Нийгмийн гэрээний эцсийн зорилго бол гэрээ байгуулагчдыг хамгаалан хадгалах явдал юм. Эцсийн зорилгыг харж байгаа хүн хэрэгжүүлэх арга замыг харж байна гэсэн үг» [15] гэжээ. Бид гэрээгээр эрх баригчдад бидний эрх ашгийг хамгаал гэсэн үүрэг хүлээлгэсэн. Гэтэл эрх баригчдын гаргасан шийдвэр гэрээний нөгөө тал буюу ард иргэдийн санаа сэтгэл, эрх ашигт огт нийцэхгүй бол яах вэ гэдэг асуудал гарч таарна. Ийм тохиолдолд асуудлыг хэрхэн шийдэх талаар улс төрийн философи сэтгэлгээнд өөрийн мөрөө тод үлдээсэн эрдэмтэн мэргэд аль хэдийнээ маш тодорхой заасан байх ажээ. Францын их сэтгэгч Бастиа Хууль хэмээх бүтээлдээ «... Заримдаа хууль тонуулыг өөгшүүлж тэр байтугай түүнд оролцож байдаг. Хууль нь тонуулаар ашиг ологч хүмүүсийн зэвсэг болсноороо тэдэнд оногдох ичих нүүр, аюулт байдал, эргэлзээнээс хуваалцаад байгаа юм шиг санагддаг. Заримдаа хууль нь шүүгч, цагдаа, шорон, жандармын бүх бие бүрэлдхүүнийг тонуулчдад үйлчлүүлэхээр томилдог ба хэрэв хэлмэгдэгч өөрийгөө зөвтгөөд байвал түүнийг гэмт хэрэгтэн мэт залхаан цээрлүүлдэг» [16] гэж өнөөгийн манай нийгэмд болж буй зүйлийг хэдэн зууны өмнө харсан мэт бичжээ. Тэгээд хэрэв байдал ийм бол яах ёстой талаар цааш нь үргэлжлүүлэхдээ, «Хууль нэг хүний эзэмшиж буй эд хогшлыг, эдгээрийг эзэмшээгүй хүмүүст өгч байна уу,

үгүй юу гэдгийг хараад үз дээ. ...Ийм хуулийг даруй устга. Яагаад гэвэл энэ нь өөрөө зөвхөн бусармаг зүйл байхаас гадна бусдыг шийтгүүлэхэд уриалан дуудаж ирээдүйн бусармаг зүйлийг тэтгэх хөрс нь болж байгаагийнх нь хувьд устгах шаардлагатай. Ийм хуулийг даруй устгахгүй бол цаашид газар авч, систем болон хөгжих аюултай» [17]гэжээ. Өнөөгийн монголын бодит байдал бол Бастиагийн харж байсан хууль тонуул, болгоомжилж байсан систем мөн юм. Тийм ч учраас нэгэнт нийгмийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байгаа эрх баригчид, тэр харилцааг зохицуулж буй үндсэн хууль, төрийн тогтолцоог өөрчлөх тухай санаа бодол монголын нийгмийн сүүлийн 10 жилийн гол хэлэлцдэг асуудлуудын нэг болсон юм. Товчдоо бол түүхийн философиор шалгагдсан хамгаалах зүйлийг нь өнөөгийн үндсэн хууль хамгаалж чадахгүй байгаа юм. Засгийн бүх эх ард түмэнд бодитойгоор шилжсэн үү гэсэн асуулт гарна. Уг нь бол хуулийг даган мөрдөх гэж байгаа ард түмэн хуулийн зохиогч нь байх учиртай. Гэтэл ард иргэд хичнээн эвлэлдэн нэгдсэн ч өөрсдөө хүлээн зөвшөөрч чадахуйц хэмжээнд үндсэн хуулийг өөрчлөх боломж хуулийн хувьд байхгүй байгаа нь хамаг зовлонгийн эх үүсвэр болж байна. Үндсэн хуулийг өөрчилж чадах уу, түүнийг хэн хийх вэ? Үүнийг хууль тогтоогчийн аугаа уужим сэтгэл, тэдний ашиг сонирхол ард түмний ашиг сонирхолтой нийцэх тэр үед л хийж чадна.

Улс төрийн харилцааны мөн чанар нь улс төрийн дэглэмээр илэрдэг. Төрийн, юуны өмнө улс төрийн эрх мэдлийг хэрэгжүүлдэг эв дүй, арга хэлбэр, хэрэглүүрүүдийг бүхэлд нь улс төрийн дэглэм гэж ойлгодог[18]. Тэгвэл нэгэнт ард түмэн өөрсдийн хүсч байгаагаар нийгмийн харилцааг зохицуулж, хэдэн мянган жилээр амьдарч ирсэн газар нутгийнхаа эзэн баялгийнхаа эзэн болох боломжийг хамгаалж чадахгүй байгаа бол үүнийг ардчилсан дэглэм гэж хэлэхэд ч хэцүү юм.

Монголчуудын улс төрийн философийн хамгийн амин чухал зангилаа асуудлуудыг 2019 онд Монгол Улсын Үндсэн хуулинд оруулсан нэмэлт өөрчлөлтүүд аль нь ч шийдэж чадаагүй юм. Эдгээр өөрчлөлтийн зах зухаас нь энэхүү өгүүлэлдээ хавсралт болгон оруулья. Уншигч та бүхэн өгүүллийн санаатай санал нийлэх бол үргэлжлүүлэн судална гэж найдаж байна.

Одоо бидний анхаарах ёстой зүйл юу вэ?

Үндсэн хуулийг шинэчлэх, өөрчлөхөөр зорьж буй энэ цаг үед монголчуудын түүхээрээ хамгийн амин чухал гэж үзэж ирсэн тэр эрхэм зүйлийг монголын ард түмэнд үлдээх тийм төр, тийм төрийн тогтолцоог бий болгох гэж л хичээх явдал. Энэ нь дээр өгүүлснээр хууль тогтоогчийн аугаа уужим сэтгэл, тэд ашиг сонирхлоо ард түмний ашиг сонирхолтой нийцүүлэх тийм аугаа уужим сэтгэл гаргахад л анхаарах ёстой санагдана.

Хавсралт:

Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзэж, эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч Улсын Их Хурлын даргатай зөвшилцөж санал болгосон бол Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар өөрөө тарах шийдвэр гаргаж болно.

16/ ард нийтийн санал асуулга явуулах. Монгол Улс өөрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх аливаа оролдлогыг үл зөвшөөрөх бөгөөд мөнхүү зорилгоор ард нийтийн санал асуулга явуулахыг хориглоно; Сонгуулийн эрх бүхий иргэдийн олонхи нь оролцсон ард нийтийн санал асуулгыг хүчинтэйд тооцож, олонхийн санал авсан асуудлыг шийдвэрлэгдсэн гэж үзнэ; [\(Энэ заалтад 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 2 дахь өгүүлбэр нэмсэн.\)](#)

1.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдлэх бөгөөд энэхүү эрхийн хүрээ, хязгаарыг хуулиар тогтооно. [\(Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.\)](#)

2.Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа далан таваас доошгүй ажлын өдөр чуулна. [\(Энэ хэсгийг 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан бөгөөд уг өөрчлөлтийг Үндсэн хуулийн цэцийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болгосон. Мөн хэсгийг 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан. Мөн хэсэгт 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөлт оруулсан.\)](#)

6.Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын нийт гишүүний олонхийн саналаар хуулийг эцэслэн батална. [\(Энэ хэсгийг 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан бөгөөд уг өөрчлөлтийг Үндсэн хуулийн цэцийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болгосон. Мөн хэсгийг 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан. Мөн хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.\)](#)

7.Улсын Их Хурлын гишүүд саналаа илээр гаргаж асуудлыг шийдвэрлэнэ. Үндсэн хууль, бусад хуульд заасан, эсхүл хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжсэн бол нууц санал хураалт явуулна. [\(Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн.\)](#)

2.Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна. Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно. [\(Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.\)](#)

Хорин наймдугаар зүйл.

1. Улсын Их Хурал үйл ажиллагааныхаа зохих салбар, чиглэлээр Байнгын хороодтой байна.

2. Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна.

Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно. ([Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.](#))

Хорин есдүгээр зүйл.

Хэвлэх

1. Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй. ([Энэ хэсгийг 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан, 2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Үндсэн Хуулийн Цэцийн 02 дугаар тогтоолоор хүчингүй болгосон, 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан](#))

2. Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална.

3. Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна. ([Энэ хэсэгт 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 1 дэх өгүүлбэр нэмсэн.](#))

Гучдугаар зүйл.

1. Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.

2. Ерөнхийлөгчөөр тавин нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно. ([Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.](#))

Ашигласан материал

1. Тойнби Ж. Арнольд. (2007). *Түүх судлал*. Монсудар ХХК. Уб., 424 дахь тал
2. Britannica. (1996). *Great books. Hegel, Kierkegaard, Nietzsche*. pp. 43, 162
3. Цолмон Д. (1999). *Америкийн нэгдсэн улсын түүх*. Уб., 32 дахь тал
4. Britannica. (2011). *Ширээний нэвтэрхий толь* (Vol. 2). Нерко паблишинг ХХК. Уб., 940 дэх тал

5. АНУ-ын Үндсэн хууль. (1999). (орч. Цолмон Д) Адмон принт ХХК. Уб., 20 дахь тал
6. Marc Landy, Sidney M.Milkis. (2008). *American Government: Balancing democracy and rights*. (2nd edition). p 375
7. Story, Ronald, Boller, Paul F. (2000). *A More perfect Union. Document in US History to 1877* (Vols. Volume 1.). Montgomery, Illionis, U.S.A. Houghton Mifflin College Div. p.35
8. Цолмон Д. (1999). *Америкийн нэгдсэн улсын түүх*. Уб., 32 дахь тал
9. Дюверже, М. (2007). *Улс төрийн байгууламж. Үндсэн хуулийн эрх зүй*. Уб., 303 дахь тал
10. Шинэ толь сэтгүүл. (1995). *Ардчилал ба эрх зүй*. (Vol. 4). УТБА. Уб., 81-95 дахь тал
11. Мөн тэнд., 81-95 дахь тал
12. Бүгд Найрамдах Польш Улсын Үндсэн хууль. (n.d.).
13. Бүгд Найрамдах Польш Улсын Үндсэн хууль. (n.d.).
14. Болд-Эрдэнэ Д. (2015). *Улс төрийн философи*. Уб., 67-68 дахь тал
15. Руссо, Ж. Ж. (2002). *Нийгмийн гэрээ ба Улс төрийн эрхийн зарчмууд*. Монсудар паблишинг ХХК. Уб., 31 дэх тал
16. Бастиа Ф. (2007). *Хууль*. (Орч. Баярбаатар Н.) Уб., 20 дахь тал
17. Чимид Б. (2006). *Өнөөгийн улс төр хуульчийн нүдээр*. Адмон ХХК. Уб., 32-33 дахь тал